



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 02 сарын 27 өдөр

Дугаар A/106

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.8, Засгийн газрын 2018 оны “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 23 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлбөрийн орлогыг ашиглах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.8, 4.1.9 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс болон батлан хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, цэргийн штаб үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, батлан хамгаалах үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэхэд идэвхи, санаачлагатай ажилласан иргэн, албан тушаалтныг урамшуулах зардалд 1.098.000 (нэг сая ерэн найман мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлбөрийн орон нутагт үлдэх орлогоос зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД

011100240